



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар A/63

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн A/143 дугаар, 2018 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн A/61 дүгээр тушаалуудаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан хавсралтад турьдсан нэр бүхий 3 ҮЦК-ийн арилжаанд оролцох эрхийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг ҮЦК-иудад анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2018 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн
.../63 дугаар тушаалын хавсралт



Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг
сэргээх ҮЦК-иудын нэрс

- | | |
|----------------------------|--------------|
| 1. "Гацуурт трейд ҮЦК" ХХК | /Ц.Хуяг/ |
| 2. "Масдак ҮЦК" ХХК | /В.Баттулга/ |
| 3. "Эс Жи Капитал ҮЦК" ХХК | /Б.Батхүү/ |